



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/226/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 261628 Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn
Аудитор: Н.Баттөгөлдөр
Утас: 261628 Цахим хаяг: battuguldurn@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2Төлбөрийн акт	19
4.3Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Г.БАТДОРЖ ТАНАА

2022.02.24 № 07/339

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 400,021.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх", "Толилуулга ба тодруулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	155,930,182.25	57,783,814.74
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
3121	Төгрөг	0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	0.00
33	АВЛАГА	3,022,226.05	-
33300	Татаас санхүүжилтийн авлага	2,985,000.00	-
335	Бусад авлага	37,226.05	-
3351	Байгууллагаас авах авлага	37,226.05	
34	УРЬДЧИЛГАА	79,465,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	79,465,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	73,442,956.20	57,783,814.74
354	Хангамжийн материал	73,442,956.20	57,783,814.74
35410	Бичиг хэргийн материал	2,187,443.20	5,522,066.00
35420	Аж ахуйн материал	194,509.00	124,494.00
35440	Шатах тослох материал	4,200,000.00	1,529,000.00
35460	Хүнсний материал	544,314.00	273,366.00
35470	Бусад хангамжийн материал	66,316,690.00	50,334,888.74
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,552,094,416.67	2,437,377,529.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,552,094,416.67	2,437,377,529.39
392	Биет хөрөнгө	1,405,597,320.59	2,055,912,340.03
39201	Барилга, байгууламж	2,339,203,104.88	2,296,194,926.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,251,780,880.41)	(1,264,845,108.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	334,965,937.66	320,241,467.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(198,010,736.69)	(233,830,009.25)
39205	Машин тоног төхөөрөмж	152,812,595.00	1,156,234,595.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,342,810.60)	(274,000,192.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,755,180.86	83,755,180.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,808,921.97)	(64,365,158.75)
39214	Бусад үндсэн хөрөнгө	59,636,065.00	59,636,065.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,832,213.14)	(23,109,426.22)
393	Биет бус хөрөнгө	146,497,096.08	381,465,189.36
39301	Програм хангамж	150,000.00	282,858,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(150,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	169,070,360.00	160,434,620.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(22,723,263.92)	(61,677,430.64)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ҮР ДҮН	1,708,024,598.92	2,495,161,344.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,985,000.00	-
413	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,985,000.00	-
4136	Бусад өглөг	2,985,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,985,000.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,705,039,598.92	2,495,161,344.13
51	Засгийн газрын хувь оролцоо	1,705,039,598.92	2,495,161,344.13

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	511,123,914.11	511,123,914.11
51101	Өмч: - төрийн	511,123,914.11	511,123,914.11
512	Хуримтлагдсан үр дүн	297,429,856.25	1,087,551,601.46
51210	Өмнөх үеийн үр дүн	794,833,472.15	297,429,856.25
51220	Тайлант үеийн үр дүн	(497,403,615.90)	790,121,745.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	896,485,828.56	896,485,828.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,708,024,598.92	2,495,161,344.13

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН	3,735,881,361.00	5,506,717,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,322,958,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,322,958,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	36,828,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	36,828,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	-	1,286,130,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,735,881,361.00	4,183,759,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,355,320,246.00	3,991,095,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,226,873,100.00	3,991,095,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	128,447,146.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	380,561,115.00	192,664,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	359,016,720.00	169,547,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,512,395.00	16,166,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,032,000.00	6,950,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,986,487,528.27	4,689,284,384.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,986,487,528.27	4,689,284,384.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,650,178,642.46	4,647,807,058.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	672,029,475.66	673,417,434.43
210101	Үндсэн цалин	513,810,134.66	531,982,745.87
210102	Нэмэгдэл	125,025,224.00	107,947,436.56
210103	Хоол унааны хөнгөлөлт	33,194,117.00	33,487,252.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,348,149.09	90,852,724.76
210201	НДШ-ийн зардал	64,141,509.08	64,680,185.02
210202	Тэтгэмжийн даатгал	6,721,173.12	6,812,994.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,601,779.30	5,277,196.93
210204	Ажилгүйдлийн даатгал	1,344,026.00	1,275,440.58
210205	Эрүүл мэндийн даатгал	13,539,661.59	12,806,907.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,832,822.24	42,626,105.62
210301	Гэрэл, цахилгаан	17,412,226.84	14,824,521.12
210302	Түлш, халаалт	28,453,507.10	25,155,243.50
210303	Цэвэр, бохир ус	4,767,088.30	2,646,341.00
210304	Байрны түрээс	3,200,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	105,724,541.96	111,758,598.58
210401	Бичиг хэргийн зардал	16,146,039.80	19,603,188.20
210402	Тээвэр, шатахууны зардал	19,677,500.00	22,101,500.00
210403	Шуудан, холбооны зардал	6,426,886.16	8,625,446.38
210404	Ном хэвлэлийн зардал	9,467,200.00	29,021,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,006,916.00	32,407,464.00
2105	Нормативт зардал	81,651,400.00	215,834,376.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	214,335,176.26

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	81,592,000.00	1,499,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	59,400.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,339,000.00	3,830,794.90
210604	Урсгал засвар	1,339,000.00	3,830,794.90
2107	Томилолт, зочны зардал	28,428,000.00	2,700,000.00
210702	Дотоод албан томилолт	28,428,000.00	2,700,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,430,349,064.00	3,109,814,075.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,425,496,704.00	3,105,374,002.43
210803	Даатгалын үйлчилгээ	983,160.00	534,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	782,100.00	488,113.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	700,000.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,238,000.00	1,769,900.00
210807	Газрын төлбөр	149,100.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	185,476,189.52	396,972,948.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,052,800.00	23,436,931.39
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	164,423,389.52	373,536,016.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	336,308,885.81	41,477,326.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,798,551.04	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,793,651.04	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,004,900.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	240,510,334.77	41,477,326.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	231,284,221.77	34,527,256.14
213305	Нэмэлт санхүүжилт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,226,113.00	6,950,070.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(250,606,167.27)	817,432,615.83
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	246,797,448.63	27,310,870.62
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,777,741.99	27,310,870.62
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	235,019,706.64	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(246,797,448.63)	(27,310,870.62)
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(497,403,615.90)	790,121,745.21

2.3 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	511,123,914.11	877,755,828.56	677,634,972.15	2,066,514,714.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	117,198,500.00	117,198,500.00
Дахин илэрхийлэх үлдэгдэл	511,123,914.11	877,755,828.56	794,833,472.15	2,183,713,214.82
Тайлант үеийн үр дүн	-	-	(497,403,615.90)	(497,403,615.90)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	297,429,856.25	1,705,039,598.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэх үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	297,429,856.25	1,705,039,598.92
Тайлант үеийн үр дүн	-	-	790,121,745.21	790,121,745.21
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	1,087,551,601.46	2,495,161,344.13

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,938,593,074.00	4,183,759,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,185,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	4,185,000.00	-
120009	Бусад орлого	4,185,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,934,408,074.00	4,183,759,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,355,320,246.00	3,991,095,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,226,873,100.00	3,991,095,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	128,447,146.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	579,087,828.00	192,664,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	557,543,433.00	169,547,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,512,395.00	16,166,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,032,000.00	6,950,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,810,145,928.00	4,183,759,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,810,145,928.00	4,183,759,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,470,852,042.19	4,142,281,673.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	672,029,475.66	678,591,975.39
210101	Үндсэн цалин	513,810,134.66	503,529,289.85
210102	Нэмэгдэл	125,025,224.00	140,404,702.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,194,117.00	34,657,983.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,385,375.13	84,844,157.75
210201	Тэтгэврийн даатгал	64,178,735.12	58,671,617.41
210202	Тэтгэмжийн даатгал	6,721,173.12	6,812,994.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,601,779.30	5,277,196.93
210204	Ажилгүйдлийн даатгал	1,344,026.00	1,275,440.58
210205	Эрүүл мэндийн даатгал	13,539,661.59	12,806,908.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,832,822.24	42,626,105.62
210301	Гэрэл, цахилгаан	17,412,226.84	14,824,521.12
210302	Түлш, халаалт	28,453,507.10	25,155,243.50
210303	Цэвэр, бохир ус	4,767,088.30	2,646,341.00
210304	Байрны түрээс	3,200,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	69,817,006.16	25,947,200.00
210401	Бичиг хэрэг	12,278,100.00	4,876,400.00
210402	Тээвэр, шатахуун	9,083,820.00	3,946,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,426,886.16	5,650,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,028,200.00	11,474,200.00
2105	Нормативт зардал	81,592,000.00	2,999,930.00
210502	Хоол, хүнс	81,592,000.00	2,999,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,339,000.00	1,338,944.90
210604	Урсгал засвар	1,339,000.00	1,338,944.90
2107	Томилолт, зочны зардал	28,428,000.00	2,700,000.00

210702	Дотоод албан томилолт	28,428,000.00	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,435,715,563.00	3,272,699,901.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,430,863,203.00	3,268,039,828.81
210803	Даатгалын үйлчилгээ	983,160.00	534,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	782,100.00	488,113.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	700,000.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,238,000.00	1,989,900.00
210807	Газрын төлбөр	149,100.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,712,800.00	30,533,458.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,712,800.00	30,533,458.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	339,293,885.81	41,477,326.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,798,551.04	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,793,651.04	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,004,900.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	243,495,334.77	41,477,326.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	243,495,334.77	41,477,326.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	128,447,146.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	128,447,146.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	128,447,146.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	128,447,146.00	-
221001	Их засвар	108,594,346.00	
222001	Тоног төхөөрөмж	19,852,800.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(128,447,146.00)	-
7	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,144,453,000.00	3,956,567,743.86	187,885,256.14	95.5
УРСГАЛ ЗАРДАЛ	4,144,453,000.00	3,956,567,743.86	187,885,256.14	95.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,144,321,800.00	3,956,567,743.86	187,754,056.14	95.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	679,380,800.00	678,591,975.39	(788,824.61)	99.9
Үндсэн цалин	503,893,300.00	503,529,289.85	(364,010.15)	99.9
Нэмэгдэл	140,760,500.00	140,404,702.45	(355,797.55)	99.7
Унаа, хоол бусад нөхөн олговор	34,727,000.00	34,657,983.09	(69,016.91)	99.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,716,600.00	84,844,157.75	(6,872,442.25)	92.5
Хангамж, бараа материалын зардал	12,423,800.00	12,390,700.00	(33,100.00)	99.7
Бичиг хэрэг	4,781,000.00	4,776,400.00	(4,600.00)	99.9
Тээвэр, шатахуун	2,506,600.00	2,490,000.00	(16,600.00)	99.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,150,100.00	4,150,100.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	986,100.00	974,200.00	(11,900.00)	98.8
Эд хогшил, урсгал засварын зардал	1,339,000.00	1,338,944.90	55.10	100.0
Урсгал засвар	1,339,000.00	1,338,944.90	55.10	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,274,456,600.00	3,106,242,401.81	(168,214,198.19)	94.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,267,466,700.00	3,101,582,328.81	(165,884,371.19)	94.9
Даатгалын үйлчилгээ	990,000.00	534,060.00	(455,940.00)	53.9
Тээврийн хэрэгслийн татвар	1,032,100.00	488,113.00	(543,987.00)	47.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,850,000.00	1,000,000.00	(850,000.00)	54.1
Мэдээллийн технологийн зардал	2,469,800.00	1,989,900.00	(479,900.00)	80.6
Газрын төлбөр	648,000.00	648,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	32,629,300.00	30,533,458.39	(2,095,841.61)	93.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,629,300.00	30,533,458.39	(2,095,841.61)	93.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,200.00		131,200.00	-
Бусад урсгал шилжүүлэг	131,200.00		131,200.00	-
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	131,200.00		131,200.00	-
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		34,527,256.14	(34,527,256.14)	-

Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		34,527,256.14	(34,527,256.14)	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,144,453,000.00	3,956,567,743.86	187,885,256.14	95.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,144,453,000.00	3,956,567,743.86	187,885,256.14	95.5
Улсын төсвөөс санхүүжих	4,144,321,800.00	3,956,567,743.86	187,754,056.14	95.5
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		6,950,000.00	(6,950,000.00)	
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЭЛ				
Байгууллагын тоо	1	1		
Ажиллагсдын тоо	49	49		
Удирдах ажилтан	2	2		
Гүйцэтгэх ажилтан	47	47		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		185,713,930.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		185,713,930.00
Бараа, үйлчилгээний зардал		185,713,930.00
Хангамж бараа материалын зардал		13,556,500.00
Бичиг хэрэг		100,000.00
Тээвэр, шатахуун		1,456,500.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,500,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		10,500,000.00
Нормативт зардал		2,999,930.00
Хоол, хүнс		2,999,930.00
Томилолт зочны зардал		2,700,000.00
Дотоод албан томилолт		2,700,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		166,457,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		166,457,500.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		192,664,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		192,664,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		169,547,500.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		16,166,500.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		6,950,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг хэрэгжүүлэх, анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулах, холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 24-ны хооронд Үндэсний аудитын газрын хоёрдугаар газрын аудитор Н.Баттөгөлдөр, ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын хоёрдугаар газрын менежер Б.Сэржмядаг, аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 01/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төрийн бодлогыг гэр бүлд суурилан хэрэгжүүлэх эрх зүй, тогтолцооны шинэчлэлд үнэт хувь нэмэр оруулж, гэр бүл, хүүхэд, залуучуудыг хамгаалах, хөгжүүлэх, төлөвшүүлэх үйлчилгээг сайжруулах замаар Монгол хүний хөгжил, үндэсний дархлааг бэхжүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа НБББББ-ийг ГБХЗХГ-ын даргын Бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/02 дугаар тушаалаар баталсан ба холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны А/24 тушаалаар батлагдсан Дотоод аудитын төлөвлөгөөний дагуу 2021 оны 2 дугаар улирлаар санхүүгийн үйл ажиллагаанд болон жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож 1.0 хувиар буюу 39,864.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 787,136.8.0 мянган төгрөгөөр буюу 46 хувиар өсөж материаллаг өөрчлөлт гарсан нь урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан тооцоо	79,465.0	0	(79,465.0)
Бараа материал	73,442.9	57,783.8	(15,659.1)
Үндсэн хөрөнгө	1,552,094.4	2,437,377.5	885,283.1
Нийт хөрөнгө	1,708,024.5	2,495,161.3	787,136.8
Өр төлбөр	2,985.0	0	(2,985.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,708,024,598.92	2,495,161,344.13	787,136.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Урьдчилж гарсан зардлын дансны эхний үлдэгдэл Бид сольюшн ХХК болон Амин хүүхэд ХХК-ийн гэрээт ажлын төлбөрийн урьдчилгааг хааж 79,465.0 мянган төгрөгөөр буурсан;
- Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь даргын тушаалаар Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр болон Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, бусад халамж, асрамжийн төвүүдэд Ковид-19 өвчний үед болон урьдчилан сэргийлэх, дэмжлэг үзүүлэхээр шаардлагатай материалуудыг

агентлагийн хүүхэд хамгааллын зардлаас худалдан авч өмнөх оны үлдэгдлээс зарцуулсан;

- Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл өссөн нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Ковид-19 цар тахлын нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, салбар дундын уялдаа, хүртээмжтэй хариу арга хэмжээг дэмжих төслийн хүрээнд нийгмийн ажилтнуудад кэйс менежментийн программ нэвтрүүлсэнтэй холбоотой таблетыг дагалдах хэрэгслийн хамт олгосон нөлөөлсөн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,462,908.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,462,908.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 318,455.2 мянган төгрөгөөр бууруулан 4,144,453.0 мянган төгрөгөөр баталсан ба төсвийн тодотгол хийгээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,144,453.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,144,453.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 3,991,095.0 мянган төгрөгийг зарцуулж, 34,527.2 буцаан төвлөрүүлэн 95.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,991,095.0 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь хангамж бараа материалын зардлаас 26,656.0 мянган төгрөг, нормативт зардлыг 2,999.9 мянган төгрөг дотоод албан томилолт 2,700.0 мянган төгрөгөөр тус тус илүү зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

			/мянган төгрөг/			
Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Хөтөлбөр, арга хэмжээ				
Нийт дүн			4,144,453,0	3,956,567.8	187,885,256,2	95.5
1	72203	Хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх	112,109.6	112,109.6	-	95.7
2	72207	Хүүхдийн хөгжил, хамгаалал	4,032,343.4	3,844,458.2	187,885,256,2	95.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн хүрэх үр дүн дүнгийн талаарх болон чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтээр авч үзвэл хүүхдээс хүлээж авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн биелэлт 74.5 хувьтай, 4 хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлт 87 хувьтай байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах

ерөнхий чиглэл"-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд бараа ажил үйлчилгээний зардлын данснаас ном хэвлэлийн зардалд өмнөх онтой харьцуулахад 19,553.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 29,021.0 мянган төгрөг зарцуулсан, ТББ-руу нийт 111 гүйлгээ буюу 431,092.5 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас харьяа аймаг, нийслэл орон нутгийн байгууллагуудад олгодог хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийг гэрээ дүгнэсэн актаар баталгаажуулж байх, анхан шатны болон дэмжих баримтыг хавсаргаж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зориулалт бусаар зарцуулахад тавих хяналтыг сайжруулахыг цаашид анхаарах шаардлагатай.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь нийт 2,553,893.2 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулж, 20,316.7 мянган төгрөгийн 3 мэдээллийг аудитын явцад хугацаа хоцроож, залруулан байршуулсан зөрчилтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсөвт зардлыг хэмнэж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж батлагдсан урсгал зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хангамж, бараа материалын зардал, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлуудад хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 43-р тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай Монгол Улсын Засгийн газрын 43-р тогтоолын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 1.1-д заалтын хүрээнд шалгасан зүйлүүд холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 136,252.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 3 албан шаардлагын биелэлт 93.3 хувь, 30.5 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилт 60.8 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	17,552.0			1	17,552.0	-
Албан шаардлага	3	85,200.0	3	85,200.0	-	-	93.3
Зөвлөмж	6	33,500.0	4	33,500.0	2	-	60.8
Нийт дүн	10	136,252.0	7	26,585.4	3	17,552.0	77.0

Цахим татварын системд худалдан авалтуудыг бүртгэх албан шаардлагыг хэрэгжүүлж шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх албан шаардлагын зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хоёр ажилтанд ажлаас чөлөөлөгдсөн хугацааны нийт 17,552.0 мянган төгрөгийн цалинг төсвөөс нөхөн олгосон боловч буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авах тухай өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Төрийн албаны зөвлөлөөс 01/1336 тоот албан бичгээр “... тухайн үеийн үүссэн нөхцөл байдал нь 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө буюу Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан хуучин Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд зааснаар хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлыг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэсэн чиглэл, зөвлөмжийг ирүүлсэн байна.

Энэхүү зөвлөмжийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 08/614 дугаар албан тоотор ХНХЯ-ны ХШҮДАГ-т хандан дэмжлэг хүссэн албан тоот хүргүүлсэн байна. Энэ асуудлыг дараагийн аудитаар үргэлжлүүлэн авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 434,548.0 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 34,527.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 400,021.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчлийн дүн 400,021.0 төгрөг нь алдаа, зөрчил тогтоосон ерөнхий материаллаг байдлын 39,825.8 мянган төгрөгөөс 360,195.2 мянган төгрөгөөр хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланг оны эцэст татан төвлөрүүлсэн 34,527.0 мянган төгрөгийг хасаж илэрхийлээгүй;
- Тайлант оны зардлын дансны 199 гүйлгээг тулган шалгахад нэмэлт санхүүжилтийн 3 гүйлгээ болох 20,317.6 төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим системд мэдээлэлгүй орхигдуулсан байна;

4.2 Албан шаардлага

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайлан, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.4.хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Батлагдсан төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах

Илрүүлэлт:

Тайлант онд цалингийн зардалд 796.8 мянган төгрөгийн гэрээт ажилтны цалинг тайлагнасан байна.

Энэ нь “Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Сангийн сайдын 2021 190-р тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай 16 дугаар зүйлийг хэрэгжүүлэн ажиллах, цалингийн зардлаас байнгын бус гэрээт ажилтны цалинг олгохгүй байх, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах зөвлөмж өгөх.

2. Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг холбогдох хууль журмын дагуу олгох

Илрүүлэлт:

Байгууллагын албан хаагчдад 11-12 дугаар саруудад нийт 42,656.9 мянган төгрөгийн 1-12 дугаар сарын илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 74.2. "Хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцоогүй бол дор дурдсанаас бусад тохиолдолд ажилтныг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно..." Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13.4 заалт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон

цахимаар бичилт хийж баталгаажуулна." Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 тогтоолын "Журам батлах тухай"-ын 2 хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам-ын 3.2. "Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйл болон Засгийн газрын 382 тоот тогтоолын журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах, илүү цагийн нэмэгдэл хөлсийг тухайн ажилласан сарын дараа сарын цалин хөлстэй хамт тооцон олгох, улирал болон хагас жил, жилийн эцсээр бөөн олгохгүй байх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх;

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант оны худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 33 гүйлгээний 150,969.9 мянган төгрөгийн худалдан авалтад НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах, худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, хяналт тавьж ажиллах;

4. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүүхэд хамгаалал, хүн амын бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн 73 зардлын гүйлгээний 153,177,4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлогоос хүүхэд хамгаалах сайн дурын ажил, журам сурталчлах хүүхдийн эрх гэх мэт зардлуудад зарцуулсан 52,420.0 мянган төгрөгийн мөнгөн урьдчилгааны тайлан бэлтгээгүй, гэрээ дүгнэсэн акт, ажлын тайлан анхан шатны дэмжих баримтын бүрдэл хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөтөлбөр арга хэмжээний зардалд мөнгөн урьдчилгааны тайлан, анхан шатны дэмжих баримтыг иж бүрэн бүрдүүлж хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	ГБХЗХГ	АХГ-2022/226/НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг оны эцэст татан төвлөрүүлсэн 34,527.0 мянган төгрөгийг хасч илэрхийлээгүй	Төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайлан, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж илэрхийлэх:	1	34,527.00	1	34,527.00						
2	ГБХЗХГ	АХГ-2022/226/НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайлан, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй. Төсвийн гүйцэтгэлийн тайланг оны эцэст татан төвлөрүүлсэн 34,527.0 мянган төгрөгийн тохируулгын тайланг бэлтгээгүй байна.	Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54-р зүйл болон Сангийн сайдын 76-р тушаалын дагуу хөтөлбөр зориулалт арга хэмжээгээр иж бүрэн бэлтгэн толилуульж байх албан шаардлага өгөх.х.	1	-			1	-				

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	ГБХЗХГ	АХГ-2022/226/НА-СТА-ТШЗ	Нэмэлт санхүүжилтийн орлогоос хүүхэд хамгаалах сайн дурын ажил, журам сурталчлах хүүхдийн эрх гэх мэт зардлуудад зарцуулсан 52,420.0 мянган төгрөгийн гэрээ дүгнэсэн акт, ажлын тайлан анхан шатны дэмжих баримтын бүрдэл хангалтгүй байна. Мөн хүүхэд хамгаалал, хүн амын бүлэгт чиглэсэн хөтөлбөр 87 арга хэмжээний 2,510,689 мянган төгрөгийн зарцуулалтыг шалгахад 73 зардлын гүйлгээний 153,177.4 мянган төгрөгийн зарцуулалтад мөнгөн урьдчилгааны тайлан бэлтгээгүй байна.	Улсын төсвийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан ажил гүйлгээнд мөнгөн урьдчилгааны тайлан, анхан шатны дэмжих баримтыг иж бүрэн бүрдүүлж хяналт тавьж ажиллах албан шаардлага өгөх.х.	1	205,597.40							1	205,597.40
4	ГБХЗХГ	АХГ-2022/226/НА-СТА-ТШЗ	Тайлант онд цалингийн зардлаас 796.8 мянган төгрөгийн гэрээт ажилтны төлбөрийг шилжүүлсэн зөрчил гарсан байна.	“Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Сангийн сайдын 2021.10.29-ний 190-р тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар хэрэгжүүлж ажиллах”, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	796.8							1	796.8

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	ГБХЗХГ	АХГ-2022/226/НА-СТА-ТШЗ	Байгууллагын албан хаагчдад 11-12 дугаар саруудад нийт 42,656.9 мянган төгрөгийн 1-12 дугаар сарын илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгосон байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн 74.2 заалт болон Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 тогтоолын "Журам батлах тухай"-ын 2 хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам-ын 3.2. "Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.	1	42,656.90								1	42,656.90
6	ГБХЗХГ	АХГ-2022/226/НА-СТА-ТШЗ	Тайлант оны 263 гүйлгээний 2,029,746.1 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 33 гүйлгээний 150,969.9 мянган төгрөгийн худалдан авалтад НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.	Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	150,969.90								1	150,969.90
Дүн					6	434,548.00	1	34,527.00	1	0	0	0	0	4	400,021.00
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал															
1	ГБХЗХГ	АХГ-2022/226/НА-СТА-ТШЗ	Тайлант онд нэмэлт санхүүжилтийн 3 гүйлгээ болох 20,316.7 мянган төгрөгийн зардлын гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг оруулаагүй байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардага өгөх.	1	20,316.70	1	20,316.70	1	20,316.70	1	20,316.70	1	20,316.70	

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	ГБХЗХГ	АХГ-2022/226/НА-СТА-ТШЗ	Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт тайлант батлагдсан төсвийн зардлын дүнд 10 хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх албан шаардлага өгөх.	1	-			1	-				
Дүн					2	20,316.70	-	-	2	20,316.70	-	-	-	-
Нийт дүн					8	454,864.70	2	54,844.60	3	20,316.70	1	20,316.70	4	400,021.00



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022

оны

02

дугаар сарын

25

№ 204 / А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/026/НЬ-СТБ-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг бэлтгэж, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгээгүй.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.4.хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Балгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Г.Батдорж, ахлах нягтлан бодогч Б.Наранцацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.СЭРЖМЯДАГ
Н.БАТТӨГӨЛДӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 003/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/026/НА-СТА-ТМЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд нийт 2,623,809.30 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас хугацаа хоцроосон 20,316,778.32 төгрөгийн ажил, гүйлгээний 3 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэсэн заалттай нийцээгүй, эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн ШААРДАХ нь гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын тооцооны нягтлан бодогч М.Цацралд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Г.Батдорж, ахлах нягтлан бодогч Б.Наранцацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

С.СЭРЖМЯДАГ

Н.БАТТӨГӨЛДӨР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264210

\\10.10.10.20\Bichig_Kherag\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-209.Docx

0010800671



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 202/А0150058
АХГ-2022/226/НБ-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд батлагдсан төсвийн зардлын дүнд 10 хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.


Энэ нь 2021 оны Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" 1.6 Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Г.Батдорж, ахлах нягтлан бодогч Б.Наранцацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ
С СЭРЖМЯДАГ
Н БАТТӨГӨЛДӨР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264210

10.10.20/Bichig_Khere/Alban_Shaardlaga/2022/0225_Auditin_2_Gazar-210.Docx

0010800674